

ХЭРЭГЛЭГЧИЙГ ХУУРЧ МЭХЛЭХ, ТӨӨРӨГДҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Ж.Батням

ДХИС-ийн УАС-ийн суралцагч, хурандаа

Хураангуй: Эрх зүйт төрийн чухал зорилтуудын нэг бол иргэнийхээ зөрчигдсөн эрхийг шуурхай, шударга байдлаар сэргээх, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх механизмыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх явдал юм.

Монгол Улсад 1990-ээд оноос хойш нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санаанд эргэлт гарч, шинэ төрлийн гэх тодотголтой гэмт хэрэг бүртгэгдэж, үүний зэрэгцээ гэмт этгээдүүдийн үйлдлийн арга нарийс ч, ашгийн төлөөх шунахайн сэдэлтэй гэмт хэрэг ихээр үйлдэгдэх болсон ба зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбогдуулан хэрэглэгчийн эрх ашиг маш ихээр хөндөгдөх болсон.

Зах зээлийн нөхцөлд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг дээд зэргээр хангасан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр хангах нөхцөлийг бий болгоход идэвхтэй нөлөөлөх замаар хэрэглэгчийн эрхийг хангахад нь туслах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж энэ чиглэлээр төрийн бодлогод нөлөөлөх явдал мөн.

Түлхүүр үг: хэрэглэгч, эрх зүй, төр, зах зээл, эдийн засаг

Удиртгал

Хууль зүйн шинжлэх ухаанд харьцуулсан эрх зүй судлалын ач холбогдлын өндрөөр үнэлэх болсон энэ үед бид өөрсдийн судалгаагаа харьцуулах арга, тэр дундаа харьцуулсан эрүүгийн эрх зүйн үүднээс улс орны эрүүгийн хууль тогтоомж дахь ижил төсөөтэй хуулийн хэм хэмжээнд дүн шинжилгээ хийж, ололттой зохицуулалтыг нутагшуулах санал зөвлөмж боловсруулахыг зорьсон билээ.

Харьцуулалт /Comparativus"-харьцуулсан гэсэн латин гаралтай үг/ эрүүгийн эрх зүй гэдэг нь өнөө цагт бие даасан салбар эрх зүй, эсвэл эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны нэг бүрэлдэхүүн хэсэг, тэрчлэн судалгааны арга, судлагдахуун нэг сэдэв, бие даасан хичээл зэрэг олон онолын маргаантай асуудал шинжлэх ухаанд өрнөсөөр байна. Бид судалгааны ажилдаа харьцуулсан эрүүгийн эрх зүйн үүднээс хандаж, өнөө цагт

харьцуулсан эрүүгийн эрх зүйг бие даасан шинжлэх ухаан гэж хүлээн зөвшөөрөх хандлагыг дэмжиж байна.

Энэ талаар ОХУ-ын эрдэмтэн, профессор Ю.А.Тихомиров болон АНУ-ын профессор Кристофер Осаке нар өөрийн бүтээлдээ¹ тус тус хүлээн зөвшөөрснийг дурдах нь зөв юм.

Эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал нь арга зүйн хувьд онолын болон хэрэглээний гэсэн хоёр чиглэлээр хөгжиж байна. Онолын чиглэл нь харьцуулсан эрүүгийн эрх зүйн онолын асуудал, эрх зүйн гүн ухаанд хамаарч байдаг бол хэрэглээний чиглэл нь эрүүгийн салбар эрх зүй², түүний институт, хэм хэмжээний хүрээнд хэрэглэгдэж байна.

Академич С.Нарангэрэл:” Харьцуулсан эрх зүй судлал бол эрх зүйн янз бүрийн тогтолцоог судлах, эрх зүйн нэг төрлийн институт, тэдгээрийн үндсэн зарчимд харьцуулалт хийхийг гол арга болгон ашигладаг хууль зүйн шинжлэх ухааны бие даасан хэсэг мөн”³ гэж тодорхойлжээ.

Германы эрдэмтэн К.Цвайгерт, Х.Кётц нар харьцуулсан эрх зүй гэсэн нэр томъёог “оюун санааны объектын хувьд эрх зүйг судлахдаа харьцуулалтын аргыг хэрэглэх” буюу “дэлхийн хамтын нийгэмлэгийн улс орнуудад оршиж байгаа эрх зүйн янз бүрийн тогтолцооны харьцуулалт” гэж ойлгоно⁴ гэжээ.

Профессор Кристофер Осакегийн үзэж буйгаар харьцуулалтыг микро болон макро түвшинд хийх бөгөөд **макро түвшинд:** эрх зүйн бүл, тогтолцооны; **микро түвшинд** эрх зүйн салбар, институт, хэм хэмжээ болон эрх зүйн ойлголт, ухагдахуунд хийгдэх харьцуулалт багтана⁵.

Хэдий бид судалгааны ажлын зорилтдоо гадаад орны эрүүгийн эрх зүйн туршлагыг судалж, ололттой зохицуулалтын нутагшуулахыг гол болгосон ч энэ хүрээнд хийгдэх судалгаагаа макро буюу эрх зүйн бүлийн түвшинд дэлгэрэнгүйгээр авч үзэхийг зориогүй болно. Учир нь эрх зүйн бүлийн асуудал нь харьцуулсан эрүүгийн эрх зүйн гол судлагдахуун биш бөгөөд, бид судалгаагаа микро

¹Ю.А.Тихомиров. Курс сравнительного правоведения. М., 1996. С. 30- 31., Кристофер Осаке. Сравнительное правоведения в схемах общая и особенная части. М., 2000. С. 10.

²Ж.Амарсанаа. Харьцуулсан эрх зүйн онолын асуудал. УБ., 2000. 38-р тал.

³ С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 218-р тал.

⁴К.Цвайгерт, Х.Кётц.Введение в сравнительное правоведение в сфере частного права. Том 1. Основы. М., 1998. С.8-9.

⁵Кристофер Осаке. Сравнительное правоведения в схемах общая и особенная части. М., 2000. С. 14-15.

түвшинд, тэр дундаа эрүүгийн хуулийн тодорхой хэм хэмжээнд харьцуулалт хийх болно.

Харьцуулсан эрүүгийн эрх зүйн чиглэлийг хүлээн зөвшөөрч, тэр чиглэлээр өөрийн бүтээлдээ тусгасан болон нэг сэдэвт бүтээлээ нийтлүүлсэн манай эрдэмтдийн⁶ бүтээлтэй танилцаад харьцуулсан эрүүгийн эрх зүй нь бусад харьцуулсан эрх зүй судлалаас дараах чиглэлээр онцлог судалгаа хийдэг болохыг тодорхойлох гэж оролдлоо. Үүнд:

1. Зөвхөн эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг \эрүүгийн хуулийн зохих зүйл, заалтыг\ өөр хооронд нь харьцуулан судалдаг;
 2. Зөвхөн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын харилцаанд үйлчлэх эх сурвалж \эрүүгийн хууль, кодекс\ мөн онолын асуудал болох гэмт хэрэг, ял, эрүүгийн хариуцлага зэрэг эрүүгийн эрх зүйн үндсэн ойлголтыг хамрах хүрээндээ багтаан судалдаг;
 3. Заавал гадаадын аль нэг улс орны эрүүгийн эрх зүйн зохицуулалтад хамаарах асуудлыг өөрийн буюу ямар нэгэн улс орныхтой жишиж үзэх замаар адил ба ялгаатай талыг хүмүүжүүлэх ажил 1-2 жил хийлгэнэ.
2. Энэ гэмт хэргийг
- а. Давтан

⁶С.Нарангэрэл. “Монгол улсын эрүүгийн эрх зүй” \тусгай анги\ УБ., 2001, Д.Мөнхтуяа. “Олон улмын эрүүгийн эрх зүй” УБ., 2001, Н.Отгончимэг. “Харьцуулсан эрх зүйн судлал” УБ., 2002,

гарган илэрхийлэх аргаар харьцуулан судлах;

Иймээс бид эрх зүйн бүлийн төлөөлөл болгож ром- германы эрх зүйн бүлийн төлөөллөөс хөрш ОХУ, социалист эрх зүйн бүлийн төлөөлөл болгож БНХАУ-ын эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээтэй харьцуулалт хийлээ.

Үндсэн хэсэг

ОХУ-н Эрүүгийн хууль: ОХУ-ын эрүүгийн хуулийн 200 дугаар зүйл. Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх

1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллага, түүний ажилтан нь худалдан авагчид бараа бүтээгдэхүүнийг зориулалт, чанарын талаар худал буруу мэдээлэл өгөх, бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, эсвэл хэрэглэгчийн хуурч төөрөгдүүлсний улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол хөдөлмөрийн хөлс болон адилтгах орлогын доод хэмжээг 100-200 дахин торгох, 2 сарын орлогыг хураах, эсвэл 180-240 цаг албан ажил хийлгэх, эсвэл засан

Д.Баярсайхан. “Харьцуулсан эрүүгийн эрх зүй судлал” УБ., 2008 он, Б.Ганболд. “Эрүүгийн эрх зүйд нэвтрэхүй”. УБ., 2012 гэх мэт.

б. Бүлэг, урьдчилсан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг
в. Их хэмжээний хохирол учруулсан бол 2 жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах, эсвэл 3 жил хүртэл хугацаагаар үйл ажиллагаа явуулах эрх хасна⁷.

Үүнийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлд заасан хэм хэмжээний диспозицтэй харьцуулан үзвэл:

<i>ОХУ-ын Эрүүгийн хуулийн 200 дугаар зүйлийн 200.1:</i>	<i>МУ-ын Эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийн 169.1:</i>
<i>Шууд объект:</i> Хэрэглэгчийн эрх ашиг, сонирхол байна.	<i>Шууд объект:</i> Хэрэглэгчийн эрх ашиг, сонирхол байна.
<i>Объектив тал:</i> Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллага, түүний ажилтан нь худалдан авагчид бараа бүтээгдэхүүнийг зориулалт, чанарын талаар худал буруу мэдээлэл өгөх, бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, эсвэл хэрэглэгчийн хуурч төөрөгдүүлсэн идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүй байна. Энэ үйлдлийн улмаас үлэмж хэмжээний хор уршиг учирснаар төгсөх материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг.	<i>Объектив тал:</i> Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан буруу жинлэх буюу хэмжих, үнэ, тарифыг өсгөх, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан жин, хэмжүүр ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатай өөрчлөх, бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, хуурамч зар сурталчилгаа явуулах зэргээр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсэн идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүй байна. Энэ үйлдлийн улмаас бусдад их хэмжээний хор уршиг учирснаар төгсөх материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг.
<i>Субъект:</i> Гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллага, түүний ажилтан байна.	<i>Субъект:</i> Гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан байна.
<i>Субъектив тал:</i> Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.	<i>Субъектив тал:</i> Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.
<i>Санкц:</i> хөдөлмөрийн хөлс болон адилтгах орлогын доод хэмжээг 100-200 дахин торгох, 2 сарын орлогыг хураах, эсвэл 180-240 цаг албан ажил хийлгэх, эсвэл засан хүмүүжүүлэх ажил 1-2 жил хийлгэнэ.	<i>Санкц:</i> хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.
<i>Хүндрүүлэх бүрэлдэхүүн:</i> Энэ гэмт хэргийг а. Давтан б.Бүлэг, урьдчилсан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг в. Их хэмжээний хохирол учруулсан бол	<i>Хүндрүүлэх бүрэлдэхүүн:</i> Энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол

⁷1996 оны 6 сарын 13-ны өдөр батлагдсан ОХУ-ын Эрүүгийн хууль. Уголовный кодекс РФ (УК РФ) от 13.06.1996 N 63-ФЗ.

<i>Хүндрүүлэх бүрэлдэхүүний санкц:</i> 2 жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх эрх хасах, эсвэл 3 жил хүртэд хугацаагаар үйл ажиллагаа явуулах эрх хасна .	<i>Хүндрүүлэх бүрэлдэхүүний санкц:</i> тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавиас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
---	---

Төсөөтэй тал нь: ОХУ-ын Эрүүгийн хуулийн 200 дугаар зүйлд гэмт хэргийн бүрэлдэхүүнээр нь болон эрүүгийн хариуцлагаар нь задлан шинжилгээг хийж үзэхэд манай улсын Эрүүгийн хуулийн хэм хэмжээтэй төрлийн болон шууд объектын шинжээрээ ижил байна. Мөн субъектийн эрүүгийн хариуцлага хүлээх насны байдал нь гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, нийтлэг субъект байхаар хуульчилсан байна. Харин энэ 2 орны эрүүгийн хуульд аль алинд нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Гэмт этгээдийн гэм буруутай үйлдэлдээ хандах сэтгэхүйн дотоод хандлага нь болох субъектив талыг хуульчлахдаа аль аль нь гэм буруугийн санаатай хэлбэр байхаар хуульчилжээ.

Ялгаатай тал: ОХУ-ын Эрүүгийн хуулийн 200 дугаар зүйлд объектив талын үйлдлийг худалдан авагчид бараа бүтээгдэхүүнийг зориулалт, чанарын талаар худал буруу мэдээлэл өгөх, бараа

бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, эсвэл хэрэглэгчийн хуурч төөрөгдүүлсэн идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүй байхаар харин манай улсын тухайд илүү дэлгэрэнгүй нарийвчлан буюу буруу жинлэх буюу хэмжих, үнэ, тарифыг өсгөх, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан жин, хэмжүүр ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатай өөрчлөх, бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, хуурамч зар сурталчилгаа явуулах зэргээр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсэн идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүй байхаар хуульчилснаас үзэхэд энэ гэмт хэргийн үйлдлийг дэлгэрэнгүй заасан нь бусад зөрчлөөс ялгах чухал зохицуулалт болжээ гэж үзэх болох юм. Харин манай эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийн 169.1-д их хэмжээний хохирол учирсан байхаар ОХУ-ын эрүүгийн хуульд үлэмж

хэмжээний хор уршиг учирсан байхыг шаарджээ. Үйлдэл, хор уршгийн хооронд шалтгаант холбоотой байна.

Нөгөөтээгүүр ОХУ-н эрүүгийн хуулийн 200 дугаар зүйлийн 200.2 буюу хүндрүүлэх бүрэлдэхүүн нь давтан, бүлэг, урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг мөн их хэмжээний хохирол учруулсан байхаар заасан бол Монгол улсын эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийн 169.2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүн нь зөвхөн хохирлын хэмжээгээр буюу онц их хэмжээний хохирол учруулсан байхаар хуульчилжээ. Мөн санкцын хувьд ихээхэн ялгаатай байдал байхгүй байх боловч торгох ялын тухайд ОХУ-ын эрүүгийн хуулийн онцлог нь хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогыг сараар тооцож ногдуулдгаараа онцлог юм.

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн Гуравдугаар бүлэг. Нийгэм журмын зах дэлгүүрийн аж ахуйн эмх дэглэмийг эвдсэн ял.

Нэгдүгээр хэсэг. Хуурмаг, чанар муутай таваар үйлдвэрлэсэн, борлуулсан ял

140-р зүйл. Үйлдвэрлэгч борлуулагч үйлдэхүүндээ хольц хийх хуурмаг юм холих, худлаар үнэнийг оруулах, муугаар сайныг оруулах, хэр тэнцэхгүй

үйлдэхүүнээр хэр тэнцэх үйлдэхүүнийг орлуулж борлуулсан мөнгөний тоо нь таван түмэн⁸ төгрөгөөс дээш хорин түмэн төгрөгөнд үл хүрэх байвал хоёр жилээс доош хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгээд борлуулсан мөнгөнийх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэх буюу дангаар шийтгэнэ. Борлуулсан мөнгөний тоо нь хорин түмэн төгрөгөөс дээш тавин түмэн төгрөгөнд үл хүрэх байвал хоёр жилээс дээш, долоон жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөнийх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Борлуулсан мөнгөний тоо нь тавин түмэн төгрөгөөс дээш хоёр зуун түмэн төгрөгөнд үл хүрэх байвал долоон жилээс дээш хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөнийх нь тооны зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Борлуулсан мөнгөний тоо нь хоёр зуун түмэн төгрөгөөс дээш байвал арван таван жилийн хугацаатай хорих буюу хугацаагүй хорихоор шийтгээд борлуулсан мөнгөнийх нь тооных нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь

⁸Нэг түмэн нь арван мянга гэсэн тоотой тэнцэнэ.

хурааж авахаар нийцүүлэн шийтгэнэ.

141-р зүйл. Хуурмаг эм үйлдвэрлэж, борлуулаад хүний биеийн эрүүл мэндэд хүнд ноцтой хор хөнөөл болоход хүрсэн байвал гурван жилээс доош хугацаатай хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийцүүлэн шийтгэх буюу дангаар шийтгэнэ. Хүний биеийн эрүүл мэндэд хүнд ноцтой хор хохирол учруулсан байвал гурван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Хүнийг үхүүлсэн буюу хүний биеийн эрүүл мэндэд онцгой хүнд ноцтой хор хохирол учруулсан байвал арван жилээс дээш хугацаатай хорих буюу хугацаагүй хорих, алахаар шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь хураан авахаар нийлүүлэн шийтгэнэ.

Тус зүйлд хэлж байгаа хуурмаг эм гэдэг бол БНХАУ-ын эмийн зүйлийг хамаарах хуульд тогтоосон хуурмаг эмд тооцогдох ба хуурмаг эмээр шийдвэрлэх эмийн зүйл, эмийн бус зүйлийг зааж байна.

142-р зүйл. Чанар муутай эм үйлдвэрлэж борлуулаад хүний

биеийн эрүүл мэндэд хүнд ноцтой хохирол учруулсан байвал гурван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Үр уршиг нь онцгой хүнд ноцтой байвал арван жилээс дээш хугацаатай хорих буюу хугацаагүй хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь хураан авахаар нийлүүлэн шийтгэнэ.

Тус зүйлд хэлж байгаа чанар муутай эм гэдэг бол БНХАУ-ын эмийн зүйлийг хамаарах хуульд тогтоосон чанар муутай эмд тооцогдох эмийн зүйлийг зааж байна.

143-р зүйл. Эрүүл хамгааллын баримжаанд үл нийцэх идээний зүйлийг үйлдвэрлэж борлуулаад идээнд сүрхий хорлогдох эндэгдэл гаргах буюу эдээнээс болсон бусад хүнд өвчин олоход хүргэсэн байвал гурван жилээс доош хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэх буюу дангаар шийтгэнэ. Хүний биеийн эрүүл мэндэд хүнд ноцтой хохирол учруулсан байвал гурван жилээс дээш долоон жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд

борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Үр уршиг нь онцгой хүнд ноцтой байвал долоон жилээс дээш хугацаатай хорих буюу хугацаагүй хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь хураан авахаар нийлүүлэн шийтгэнэ.

144-р зүйл. Үйлдвэрлэгч, борлуулагч идээний зүйлд нь хортой, хориотой идээний бус эд хольсон буюу хортой, хориотой идээний бүх түүхий эд хольсныг тодорхой мэдэж байгаа идээг борлуулсан байвал таван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэх буюу дангаар шийтгэнэ. Идээнд сүрхий хорогдох эндэгдэл гарах буюу идээнээс болсон бусад хүнд өвчин олоход хүргэж хүний биеийн эрүүл мэндэд хүнд ноцтой хор хөнөөл учруулсан байвал таван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Хүнийг үхүүлсэн буюу биеийн эрүүл мэндэд онцгой хүнд ноцтой хохирол учруулсан байвал тус хуулийн 141-р зүйлийн тогтоолоор шийтгэнэ.

145-р зүйл. Хүний биеийн эрүүл мэндийг батлах тухай улсын баримжаа, ажил төрлийн баримжаанд үл нийцэх эмнэлгийн хэрэгсэл эмнэлэгт хэрэглэх эрүүл хамгаалалтын материалыг үйлдвэрлэсэн буюу хүний биеийн эрүүл мэндийг хамгаалах тухай улсын баримжаа, ажил төрлийн баримжаанд үл нийцэх эмнэлгийн хэрэгсэл эмнэлэгт хэрэглэх эрүүл хамгаалалтын материал болохыг тодорхой мэдэж байгаад борлуулж, хүний биеийн эрүүл мэндэд хүнд ноцтой хор хохирол учруулсан байвал таван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Үр уршиг нь онцгой хүнд ноцтой байвал таван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Үйл байдал нь онцгой хар хортой байвал арван жилээс дээш хугацаатай хорих буюу хугацаагүй хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тоонх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь хураан авахаар нийлүүлэн шийтгэнэ.

146-р зүйл. Хүний биеийн ба эд хөрөнгийн амар төвшнийг батлах улсын баримжаа, ажил төрлийн

баримжаанд үл нийцэх захиргааны хэрэгсэл, даралтад сав, шатамхай, тэсрэмтгий бодис буюу хүний биеийн ба эд хөрөнгийн амар төвшнийг батлах тухай ажил төрлийн баримжаанд үл нийцэх үйлдэхүүн болохыг тодорхой мэдэж байгаад борлуулж хүнд онцгой үр уршиг татсан байвал таван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тооных нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Үр уршиг нь онцгой хүнд ноцтой байвал таван жилээс дээш хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тооных нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ.

147-р зүйл. Хуурмаг үр тарианы эм, хуурмаг малын эм, хуурмаг эмийн бордоо үйлдвэрлэсэн хуурмаг буюу хүчингүй болсон үр тарианы эм, малын эм химийн бордоо болохыг тодорхой мэдэж байгаад борлуулсан эсвэл үйлдвэрлэгч, борлуулагч нь хэр тэнцэхгүй үр тарианы эм, малын эм химийн бордоо, үрээр тэнцэхгүй үр тарианы эм, малын эм химийн бордоо, үрийг орлуулаад үйлдвэрлэлд нэлээд их хохирол учруулсан байвал гурван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тооных нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн

шийтгэх буюу дангаар шийтгэнэ. Үйлдвэрлэлд хүнд их хохирол учруулсан байвал гурван жилээс дээш долоон жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тооных нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэнэ. Үйлдвэрлэлд онцгой хүнд их хохирол учруулсан байвал долоон жилээс дээш хугацаатай хорих буюу хугацаагүй хорихоор шийтгээд борлуулсан мөнгөний тооных нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь хураан авахаар нийлүүлэн шийтгэнэ.

148-р зүйл. Эрүүл хамгаалалтын баримжаанд үл нийцэх засал чимэглэлийн эдлэлийг үйлдвэрлэсэн эсхүл эрүүл хамгаалалтын бригад эрүүл мэндэд үл нийцэх засал чимэглэлийн эдлэл гэдгийг тодорхой мэдэж байгаад борлуулж хүнд ноцтой хохирол учруулсан байвал гурван жилээс доош хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгээд борлуулсан мөнгөний тооных нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэх буюу дангаар шийтгэнэ.

149-р зүйл. Тус хуулийн 141-р зүйлээс 148-р зүйлд заасан үйлдэхүүнийг үйлдэж борлуулаад дээр дурдсан зүйлүүдэд тогтоосон ялыг хийсэнд үл тооцогдох боловч борлуулалтын мөнгөний тоо нь таван

түмэн төгрөгөөс дээш байвал тус хэсгийн 140-р тогтоол ёсоор ял тогтоож шийтгэнэ. Тус хэсгийн 141-р зүйлээс 148-р зүйлд жагсаасан үйлдэхүүнийг үйлдвэрлэж борлуулаад дээр дурдсан ялыг хийсэнд тооцогдох бөгөөд бас тус хэсгийн 140-р зүйлд тогтоосон ялыг хийсэнд тооцогдсон байвал хүнд жишгээр шийтгэх тогтоол ёсоор ял тогтоож шийтгэнэ.

150-р зүйл. Тус хэсгийн 140-р зүйлээс 148-р зүйлд тогтоосон ялыг нэгж хийсэн байвал нэгжийг зоосоор

яллахаар шийтгээд түүнийг шууд хариуцаж байгаа эрхлэн хамаарагч болон бусад хариуцлагатай хүнийг дээр дурдсан зүйлүүдийн тогтоол ёсоор шийтгэнэ⁹. Үүнийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийн 169.1-д заасан хэм хэмжээний диспозицтэй харьцуулан үзвэл:

<i>БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 140 дүгээр зүйл:</i>	<i>МУ-ын Эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйл:</i>
<i>Шууд объект:</i> Хэрэглэгчийн эрх ашиг байна	<i>Шууд объект:</i> Хэрэглэгчийн эрх ашиг, сонирхол байна.
<i>Объектив тал:</i> Үйлдвэрлэгч борлуулагч үйлдэхүүндээ хольц хийх хуурмаг юм холих, худлаар үнэнийг оруулах, муугаар сайныг оруулах, хэр тэнцэхгүй үйлдэхүүнээр хэр тэнцэх үйлдэхүүнийг орлуулж борлуулсан мөнгөний тоо нь таван түмэн ¹⁰ төгрөгөөс дээш хорин түмэн төгрөгөнд үл хүрэх байвал хэмээн материаллаг бүрэлдэхүүнтэй, хор уршиг учирснаар төгсөхөөр хуульчилжээ. Мөн 141-150 дугаар зүйлд халдлагын зүйл нь өөр өөр байхаар хуульчилсан ба хохирлын хэмжээнээс хамааруулан оногдуулах ял нь өөрчлөгдөж байна.	<i>Объектив тал:</i> Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан буруу жинлэх буюу хэмжих, үнэ, тарифыг өсгөх, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан жин, хэмжүүр ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатай өөрчлөх, бараа бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хэмжээ, хэрэглээний шинж байдлын талаар зориуд худал мэдээлэл өгөх, хуурамч зар сурталчилгаа явуулах зэргээр хэрэглэгчдийг хуурч мэхэлсэн, төөрөгдүүлсэн идэвхтэй үйлдэл, эс үйлдэхүй байна. Энэ үйлдлийн улмаас бусдад их хэмжээний хор уршиг учирснаар төгсөх материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг.
<i>Субъект:</i> Гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн этгээд байна ¹¹ . Мөн хэрэг хариуцах чадвартай үйлдвэрлэгч, борлуулагч байна.	<i>Субъект:</i> Гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн этгээдэд эрүүгийн

⁹Б.Батзориг, Э.Зууннасан. “БНХАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн заргын хууль” УБ., 2006. 36-39 дахь тал.

¹⁰ Нэг түмэн нь арван мянга гэсэн тоотой тэнцэнэ.

¹¹БНХАУ-ын 8 дугаар хуралдааны тус улсын Ардын төлөөлөгчдийн их хурлын 5 дугаар

	хариуцлага хүлээлгэнэ ¹² . Мөн хэрэг хариуцах чадвартай, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны байгууллагын ажилтан байна.
<i>Субъектив тал:</i> Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ	<i>Субъектив тал:</i> Гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ
<i>Санкц:</i> хоёр жилээс доош хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгээд борлуулсан мөнгөнийх нь зууны тавиас дээш, хоёр дахинаас доош зоосоор яллахаар нийлүүлэн шийтгэх буюу дангаар шийтгэнэ.	<i>Санкц:</i> хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

хуралдаанаас 1997 оны 3 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйл.

¹² 2002 оны 1 сарын 3-ны өдөр батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 4 дүгээр бүлэг 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт.

Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинжийг нарийвчлан судалж, энэ төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын түүхэн уламжлал, шинэчлэлийг судалж, улмаар энэ гэмт хэргийг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хуулийн зохицуулалт, гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийн онцлогийг судлахын зэрэгцээ хөрш орнуудын эрүүгийн хууль тогтоомжид харьцуулалт хийж, одоо хийгдэж эхлээд байгаа эрх зүйн шинэчлэл тэр дундаа шинээр батлагдсан эрүүгийн хуульд дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Дундад буюу шинэ үеийн Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомжууд өөрөөр хэлбэл 1926 оны Шүүх цаазын бичгээс өнөөг хүртэл хэрэглэгчийг эрх ашгийг хамгаалан буруу жинлэсэн, хэмжсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцон хуульчилж ирсэн бөгөөд энэ нь Монголчуудын аж амьдрал, соёл иргэншил, зан заншил, шашин шүтлэг, эрх зүйн сэтгэлгээний онцлогтой холбоотой. Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх гэмт хэргийг хуульчилсан байдал нь зарим талаар орчин цагийн эрүүгийн хуулийн зохицуулалтаас илүү тодорхой, уг гэмт хэргийг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлагыг ялгамжтай оногдуулах нөхцөлийг хангасан зэрэг давуу талтай бөгөөд уламжлал нь цааш цаашдаа уламжлагдан улам боловсронгуй болсон төдийгүй шинэ агуулгаар баяжуулж ирсэн байна;

2. Одоо үйлчилж буй Эрүүгийн хуульд хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх гэмт хэргийг хуульчлахдаа гэмт хэргийн объектив талын шинжид заавал хор уршиг учирснаар гэмт хэрэг төгсөхөөр материаллаг бүрэлдэхүүнтэй хуульчилсан нь энэ гэмт хэргийн хор уршгийг тогтоох шаардлага тавигдаж, амьдралд энэ нь хэрэгжих байдал дутмаг байна;

3. Энэ гэмт хэргийг гэмт этгээд дангаараа үйлдэхээс гадна хамтын үйл ажиллагаагаар буюу хуулийн этгээд үйлдэж болох бөгөөд түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь гагцхүү хувь хүнд ногдуулдгаас энэ гэмт хэрэгт хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын асуудал орхигдож байна;

4. Бидний харьцуулан судалсан гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомжид энэ гэмт хэргийн объектив талын үндсэн шинж болох хохирлын хэмжээ бага байгаа нь энэ гэмт хэргийг шалган шийдвэрлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чухал зохицуулалт болсон байна;

5. Энэ гэмт хэргийн одоогийн эрүүгийн хуулийн төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх онцлогийг судалж үзэхэд энэ гэмт хэргийн бусад гэмт хэрэгтэй, ялангуяа барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийг хууль бусаар ашиглах гэмт хэрэгтэй төсөөтэй бөгөөд, давхар зүйлчлэгдэх хэргүүд боловч, бодит байдал дээр зүйлчлэл давхар хийгдэхгүй байна.

6. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр батлагдсан эрүүгийн хуулийн хэм хэмжээнд дүгнэлт хийж үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг, тэр дундаа хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан хуулийн холбогдох хэм хэмжээг гэмт хэргээс хас ч хуульчилсан нь хуулийн хийдлийг бий болгох учир зарим нэг үйлдэл, эс үйлдэхүйг заавал гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага ногдуулах асуудлыг орхигдуулжээ.

Санал

Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн тодорхойлолтын нарийвчлан судалж, энэ төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын түүхэн уламжлал, шинэчлэлийг судалж, улмаар энэ гэмт хэргийн одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хуулийн зохицуулалт, гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийн онцлогийг судлахын зэрэгцээ хөрш орнуудын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдалд дүн шинжилгээ хийж, мөн эрүүгийн хуулийн шинэчлэлийн хүрээнд батлагдсан эрүүгийн хууль болон зөрчлийн тухай хуульд дүн шинжилгээ хийж, харьцуулан судлаад дараах саналыг бид дэвшүүлж байна. Үүнд:

1. Энэ гэмт хэргийг хууль тогтоогч хор уршиг учирсан байхаар хуульчилсан бөгөөд практик тэрхүү хор уршгийг хэт өндөр байхаар хуульчилснаас иргэдийн зөрчигдсөн эрхээ хамгаалуулах боломжийг хязгаарлаж, цагдаагийн байгууллагад нэг ч гомдол мэдээлэл ирээгүй байгаа нь үүнтэй холбоотой юм. Иймээс энэ гэмт хэргийг 2016 оны 9 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчлэх шинэ Эрүүгийн хуульд нэмэлтээр хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх үйлдлийг хуульчилж, объектив тал үндсэн шинж болох хохирлын хэмжээг багасгаж хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах;

2. Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх үйлдлийг шинэ эрүүгийн хуульд хуульчлахдаа гэмт хэргийн субъект нь зөвхөн хувь хүн буюу үйлдвэр, худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтан байхаас гадна хуулийн этгээд үйлдэж болохыг анхаарч, хуульчлах;

3. Үйлдвэр, үйлчилгээ, худалдааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоог сайжруулж татварын нэгдсэн системээр дамжуулан хянах зэрэг болно.

Ашигласан материал

1. Монгол улсын Үндсэн хууль. 1992
2. Монгол улсын Эрүүгийн хууль. 2002
3. Монгол улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 2015 он
4. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль. 2003

5. Захиргааны хариуцлагын тухай хууль. 1993
6. Орчуулсан Б.Батзориг, Э.Зууннасан. БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль. 2006
7. БНМАУ-ын шүүх цаазын бичгүүдийн эмхэтгэл. (цуврал). УБ. 2002
8. Авирмэд.Э, Дашцэдэн.Д, Совд.Г. “Монгол хууль”. УБ.1997
9. Авхиа.Ж.”БНМАУ-ын Эрүүгийн зүйн тусгай анги”.УБ.,1979
10. Авхиа.Ж, Ганболд.Б.”Монгол улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн тайлбар”.УБ.,2002
11. Адъяабазар.Д.”1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт 1-р дэвтэр”.УБ.,1998
12. Алтангэрэл.Т.”16-17-р зууны Монгол цаазын бичгүүд”.УБ.,1999
13. Амарсанаа.Ж.”Хууль зүйн тайлбар толь”.УБ.,2003
14. Гантөмөр.Г. ”Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол”.УБ., 2003
15. Гантөмөр.Г. ”Гэмт хэргийн бүрэлдэхүүний онол”.УБ., 2011

Гадаад хэлээр

16. Гаухман. Л.Д. Максимов С.В.Уголовное ответственность за преступление в среде экономики”.1996г
17. Уголовный кодекс Японий. Санкт- Петербург. 2002 г
18. Уголовный кодекс Бельгий СПБ.изд Юридический центр Пресс” 2003
19. Уголовный кодекс Израйлий СПБ.изд Юридический центр Пресс” 2003
20. Уголовный кодекс Республики Молдава СПБ.изд ”Юридический центр Пресс” 2001.
- Уголовный кодекс Тайланда СПБ.изд Юридический центр Пресс” 2001